



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.24 № 679
танай _____ -ны № _____ -г

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАТНОРОВ
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Батноров сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай

• 232420707

хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Батноров сумын Монгол ардын намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Батноров сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Батноров сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ж.ГАНБААТАР/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

/Д.ОЮУНТУЯА/


БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

/Ц.БИЛЭГСАЙХАН/

АУДИТОР

/Ц.ХАТАНБОЛД/



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 .Эрүүл мэнд

1.1.1.Орон нутагт дутагдалтай байгаа эмч, мэргэжилтнийг бэлтгэх бодлогыг тодорхойлж, тэднийг чадавхжуулах, хүний нөөцийн нийгмийн баталгааг ханган ажиллана.

1.1.2.Нийт иргэдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулна.

1.1.3.Хуучин эмнэлэгт их засвар хийж хэвтэн эмчлүүлэгсдийн орны тоог нэмэгдүүлнэ.

1.1.4.Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд анхаарч ажиллана.

1.1.5.Эмч, сувилагч, мэргэшсэн асрахуйн ажилтныг чадавхжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.

1.1.6.Эрүүл мэндийн төвийг сумын төв дотор иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ түргэн шуурхай үзүүлэхэд дуудлагын машинтай болгоно.

1.1.7.“Элэг бүтэн Монгол”, Хүүхдийн “Эрүүл шүд”, Эмэгтэйчүүдийн “Умайн хүзүүний хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг сум орон нутагтаа хэрэгжүүлнэ.

1.2. Боловсрол

1.2.1.Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

1.2.2.Бага, дунд боловсролын сургалтын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяас тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.

1.2.3.Үндэсний хэл, бичгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.4. Сургууль, цэцэрлэгийн багш, сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйч залуу боловсон хүчнийг бэлтгэж чадавхжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.

1.2.5.Сурагчийн ширээ сандлыг шинэчлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.6.Орон нутагт шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор “Зөгийн үүр” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.2.7.Элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан багш, сурагчдын нийгмийн баталгааг ханган ажиллахад анхаарч ажиллана.

1.2.8.Шинэ цэцэрлэгийг бүрэн ашиглалтад оруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

1.2.9.Бэрх хотын Ерөнхий боловсролын сургуулийн гадна цонх, хаалга шинэчлэх.

1.2.10.Бэрх хотын Цэцэрлэг, сургуулийн орчныг камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.2.11.Бэрх хотын Бага сургуулийн багш нарын барилгыг буулгаж, шинээр багш нарын байр барих.

1.2.12. Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, байрыг засах.

1.2.13. Бэрх хотын сургуулийн дотуур байрны тавилга, бусад хэрэглэлүүдийг шинээр тохижуулах.



1.2.14. Бэрх хотын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дотор халаалтын шугамыг шинэчлэх.

1.3. Халамж, хөдөлмөр эрхлэлт

1.3.1. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвийг тохижуулах.

1.3.2. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, мэдлэг, ур чадвар олгох сургалтуудыг зохион байгуулах.

1.3.3. Жил бүхэн баг тус бүрээс хоёр иргэнийг малжуулах хөтөлбөрт хамруулна.

1.4. Соёл, спорт

1.4.1. Соёлын бүтээлч ажлын нэрийн утга санааг өөрчлөх дэмжиж, аялал жуулчлалд зориулсан, кино урлаг, сонгодог урлаг, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулна.

1.4.2. Иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, түүний хамрах хүрээг өргөжүүлэн фитнес төв байгуулах.

1.4.3. Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын аймаг, бүс, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

1.4.4. Соёлын үйл ажиллагааг сайжруулж, иргэдэд тохь тухтай үзвэр үйлчилгээг үзүүлэхийн тулд үзвэрийн сандлыг шинэчлэх ажлыг зохион байгуулна.

1.4.5. Сумын хэмжээнд соёлын ажилтан боловсон хүчнийг бэлтгэж, чадавхжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.

1.4.6. Төрөн гарсан алдар цуутай ахмад тамирчдын нэрэмжит тэмцээн уралдааныг зохион байгуулах.

1.4.7. Соёлын үйл ажиллагааг чанартай олон хүргэх зорилтын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээр хангаж ажиллах.

1.4.8. Ахмадын аварга шалгаруулах спортын тэмцээнийг нэрэмжит болгон жил бүр зохион байгуулж хэвшинэ. (Дардас, шугаман бүжиг, soft volleyball)

1.5. Хүүхэд гэр бүлийн хөгжил

1.5.1. Гэр бүл, хүүхдэд хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг сургалтын төвтэй болно. Сэтгэл зүйчтэй болж ажиллуулна.

1.5.2. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

1.5.3. Суманд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх сумын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5.4. Гэр бүл рүү чиглэсэн сургалтыг тогтмол хэрэгжүүлнэ.

1.5.5. Архидалтгүй сум хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуй

- 2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.2. Малын тоог чанарт шилжүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, "Монгол мал арга" хэмжээг сумандаа хэрэгжүүлнэ.
- 2.1.3. Малчдыг хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, суманд ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 2.1.4. Малаас гарах түүхий эд болон махыг гадаад зах зээлд 1.5.6. Төрийн албан хаагчдыг ажиллаа сэтгэл амар хийхэд анхаар ч тэдний хүүхдүүдийн аюулгүй чөлөөт цаг завьг үр бүтээлтэй өнгөрөөх гэрийн даалгавраа хийх орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд өдөр өнжүүлэх төвийг байгуулна.
- 2.5.5. Бэрх хотыг залуучуудын сургалт, спорт хөгжлийн төвийг барьж байгуулна.
- 2.5.6 Малаас гарах түүхий эд болон махыг гадаад зах зээлд гаргаж, нэмүү өртөг өртөг шингээн гаргах боломжийг илэрхийлж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.1.7. Малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр олон талт жижиг дунд үйлдвэрүүдийг бий болгон ажиллана.
- 2.1.8. Шинээр Малчин болж буй залуу малчдыг урамшуулж, дэмжин гаргана.
- 2.1.9. Бүх багын төв дээр халуун усны газрыг байгуулна.
- 2.1.10. Гадаад харилцааг сайжруулж Мал аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах болно.
- 2.1.11. Багын Засаг дарга нарыг тээврийн хэрэгсэл, орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангана.
- 2.1.12. Баг бүрд тэжээлийн ургамал тариалах атаршсан газрыг сэргээж, малчдад ногоон тэжээл тариалах боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.13. Бэрх хотын мал төхөөрөх бага оврын үйлдвэр барих.

2.2 .Аялал жуулчлал

- 2.2.1. Аялал жуулчлалын авто зам дагуу түр буудаллах цэг байгуулна.
- 2.2.2. Суманд дурсгалт газрын мэдээллийн төвийг барьж байгуулна.
- 2.2.3. Аялал жуулчлалын ач холбогдол бүхий газруудыг google map дээр байршуулах мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
- 2.2.4. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 2.2.5. Бэрх хотын Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.

2.3. Дэд бүтэц

- 2.3.1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг бүрэн хийж дуусгана.
- 2.3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон, хямд өртөгтэй/ орон сууцны хангамжийг сумын хэмжээнд нэмэгдүүлнэ.
- 2.3.3. Хөгжлийн төлөвлөлтөд ногоон байгууламж, усан оргилуур, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.



- 2.3.4. "ХАУС" хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид болон ард иргэдийг орон сууц худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх, эрх зүйн орчин судалж, иргэдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 2.3.5. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээл олгох олон улсын төсөл хөтөлбөрийг судлан хэрэгжүүлнэ.
- 2.3.6. Дулааны шугамын ажлыг айл, өрх, аж ахуй нэгжүүд рүү татах ажлыг эхлүүлнэ.
- 2.3.7. Төв доторх авто замын ажлыг эхлүүлнэ.
- 2.3.8. Тэнгэрийн Андгай цогцолборын хооронд хатуу хуучлалтай авто замаар холбох ажлыг мэргэжлийн компанитай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3.9. Суурин газарт хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.10. Төвд үүрэн телефоны сүлжээг өргөтгөж, 3,4-р багт сүлжээ шинээр тавих ажлыг зохион байгуулна.
- 2.3.11. Үерийн ус зайлуулах хоолойг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.3.12. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан томоохон аж, ахуй нэгж, салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 2.3.13. Суурин газар байгаа хуучирч муудсан, эзэмшил нь тодорхойгүй, иргэд олон нийтийн аюулгүй амгалан байдалд сөргөөр нөлөөлөхүйц барилга, байгууламжийг тогтоон газрыг чөлөөлүүлэх, буулгах, шинээр бүтээн босгож эдийн засаг, нийгмийн эргэлтэд оруулна.
- 2.3.14. Гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.
- 2.3.15. Айл өрхүүд өргөжин тэлж байгаа энэ үед 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам нэмж барин, эрчим хүчний тасалдлыг арилгана.
- 2.3.16. Төвд камержуулагчийн системийг бүрэн нэвтрүүлнэ.
- 2.3.17. Бэрх хотын малчны хороололд 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барина.
- 2.3.18. Бэрх хотын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.
- 2.3.19. Бэрх хотын өнгө үзэмжийг сайжруулах, нийтийн эзэмшлийн гудамж талбай, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, явган хүний зам барьж байгуулах.
- 2.3.20. Бэрх хотын төвлөрсөн хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, хот суурин газрууд хог хаягдлын зориулалтын байгууламжтай болно.
- 2.3.21. Бэрх хотод үерийн ус зайлуулах системийг байгуулна.
- 2.3.22. Бэрх хотын гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- 2.3.23. Бэрх хотын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл.
- 2.3.24. Бэрх хотын нийтийн орон сууцны дотор шугам шинэчлэх.
- 2.3.25. Бэрх хотын төв замын гэрэлтүүлэг.

2311/Уурин
СНОА0046 9074082



ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд анхаарч "НОГООН СУМ" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.2. Жил бүр 3-5 мянган мод тарих замаар ойн сан, хамгаалалтын ойн зурвасыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангана.
- 3.3. Хууль бус үйл ажиллагааг таслан зогсоон.
- 3.4. Булгийн ихүүдийг түшиглэсэн ногоон байгууламжуудыг нэмэгдүүлнэ
- 3.5. Ойжуулах мод үржүүлгийн газрыг хийж гүйцэтгэнэ.
- 3.6. Байгалын өнгөт чулууг ухагчдыг таслан зогсоон.
- 3.7. Ховордсон Ан амьтдаа хамгаалах, сэргээн нутагшуулах, баг бүрд идэвхтэн байгаль хамгаалагчдыг олноор би болгож байгаль дэлхийгээ хамгаалж ажиллана.
- 3.8. Иргэн бүр мод тарьж ногоон орчин бүрдүүлж "ЭКО СУМ" болгоно.

Мэдээллийг бэлтгэсэн БАТНОРОВ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН

ХОРООНЫ ДАРГА:  Б.ЖАВХЛАНБАЯР



2024 оны 07 сарын 23 өдөр

